

БНМАУ ДАХЬ БУДДЫН ФИЛОСОФИЙН СУДЛАЛ

Монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ олон зуун жилийн турш түүхэн хөгжлийг туулсан бөгөөд нийгмийн ахуй, ухамсар, бие хүний зан суртахууны асуудлуудыг хөндөн боловсруулж, үзэл санааны янз бүрийн урсгалууд үүсэн тэмцэлдэж ирсэн билээ. Монголын философийн хөгжилд эртний Энэтхэгийн буддын философи ихээхэн нөлөөлсөн юм. Монголын сэтгэгчид буддын философийн диалектик болон логикийн үзэл санааг уламжлан авч, түүнийг цаашид хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрийг оруулжээ. Нагаржуна хийгээд Арьядева, Асанга хийгээд Васубандху, Дигнага хийгээд Дхармакирти, Чандракирти хийгээд Шантидева, Шантаракшита хийгээд Камалашила нарын зэрэг Энэтхэгийн нэрд гарсан олон олон сэтгэгчдийн ном зохиолыг монголчууд нарийвчлан судалж, тайлбарлаад зогсохгүй, тэрхүү өв санд тулгуурлан буддизмын дотор багтаж буй мэдлэгийн янз бүрийн салбараар өвөрмөц эх бүтээлүүдийг ч туурвижээ.¹

Монгол орон буддизмын ном зохиолын арвин баялаг өв сантай юм. Тухайлбал буддын шашны ном зохиолын зэрэгцээ шинжлэх ухааны янз бүрийн салбараар эртний энэтхэгийн сэтгэгчдээс бичсэн шасдар судрын алдарт чуулган болох Ганжуур (108 боть), Данжуурыг (225 боть) нэрлэж болно. Дийлэнх олонх нь эх самгарди хэлээрээ хүрч ирж чадаагүй эдгээр ном зохиол төвд, монгол хэлээр, тэгэхдээ янз бүрийн хувилбараар хадгалагдан байна. Иймээс ч БНМАУ-ын номын сангуудад хадгалагдаж байгаа бараг сая шахам тооны төвд, монгол ном зохиолууд буддын судлалын хувьд эрдэм шинжилгээний ихээхэн үнэ цэнэтэй юм.

Ер нь буддизмыг, тухайлбал буддын философийг судлах явдал Монголын философийн түүхийн шинжилгээний нэг чухал зорилт мөн.

Монголын ард түмний философи сэтгэлгээний түүхийг судлах ажлыг БНМАУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн Ч.Жүгдэр анхлан хийж эхэлсэн юм. Түүний бүтээлүүдэд² Монголын философийн түүхийг судлах арга зүйн асуудлуудыг авч үзэж, түүний хөгжлийн үндсэн үе шатууд, хувьсгалаас өмнөх үеийн Монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний гол гол урсгалуудыг тодорхойлжээ. Ч.Жүгдэр Монгол оронд буддын философи дэлгэрэн хөгжсөн түүхийг тайлбартны

¹ С.Гомбожав. Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл. "Монголын судлал", УБ., 1959. 1 боть. 28 дахь дэвтэр.

² Ч.Жүгдэр. Развитие философской мысли Монголии в XIX с, канд дис.М, 1964. Основные веки история философии монгольскойго народа, -"История общественной мысли", М., 1972, XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжилт. УБ., 1972, З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл, УБ., 1978; XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжлийн тойм УБ., 1984.

(XVI-XVIII) болон шинэтгэгчдийн гэсэн (комментаторский и реформаторский этапы) хоёр үндсэн үе болгож хуваасан байна. Эхний үеийн гол төлөөлөгчид болон Зая бандид Лувсанпэрэнлэй (XVII зуун), сүмбэхамба Ишбалжир (XVIII зуун), Алша лхарамба Агваандандар (XVIII зууны эцэс-XIX зууны эх), гэвш Лувсанчүлтэм (XVIII зуун) болон нэрт сэтгэгчид эртний Энэтхэгийн хийгээд төвдийн буддын сэтгэгчдийн үзэл санааны өв санг хүлээн авч эзэмших, түүнийг тайлбарлаж сурталчлан дэлгэрүүлэх ажлыг голлон хийж байжээ. Тэдний бүтээл үндэсний философи сэтгэлгээний хөгжилд чухал түлхэц болж байв. Шинэтгэлийн үеийн нэрд гарсан төлөөлөгчдөөс хамба Агваанхайдав түүний шавь цорж Агваанбалдан, хутагт Данзанравжаа, аграмба Дандар, гавьж Данзан зэрэг эх оронч сэтгэл санаатай сэхээтэн лам нарыг юуны өмнө дурьдаж болно. Үндэсний тусгаар тогтнолыг олж авах үзэл санааг номлох, феодал ангийн дээд хэсэг, ялангуяа дээд лам нарын харгис үйл ажиллагааг илчлэн шүүмжлэх, буддын шашны анхны ёс горимыг хатуу чанд мөрдөн шашныг “цэвэр ариун” байлгах болон шашны сургалтад шинэчлэлт хийхийг шаардах, орос болон Европын соёл, философийн системүүдтэй танилцахыг шаардах зэрэг үзэл санаа, үйл ажлаар тэдний шинэтгэх дэвшилтэт үзэл илэрч байв.

Хувьсгалаас өмнөх үеийн Монголын (төвд хэлт) философи бол буддын философийн уламжлалт судар шасдарыг судалж тайлбарлахаар хязгаарласангүй диалектик, логик, танин мэдэхүйн болон нийгэм-ёс суртахууны нэлээд нарийн асуудлуудыг тавьж шийдвэрлэх гэсэн оролдлого, сонирхлоор тодорхойлогдож байсныг доктор Ч.Жүгдэрийн судалгаа харуулж байна. XIX зууны эцэс XX зууны эхэн үеийн монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээ бол олон янзын урсгал чиглэлийн тэмцлээр дүүрэн байсан бөгөөд тэр үеийн тэргүүний сэтгэлгээ нь Оросын тэргүүний соёлын нөлөөн дор хөгжин, улмаар 1921 оны Монгол ардын хувьсгалын үзэл санааны нэг уг сурвалж болсон билээ.

“З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл” гэсэн нэгэн сэдэвт бүтээлдээ Ч.Жүгдэр дхармын (номын) тухай буддистуудын онтологи сургаал, тэдний танин мэдэхүйн онол, тухайлбал буддизм дахь хоёр үнэний үзэл, түүнчлэн буддын философийн түүхийн тухай асуудлыг авч үзэж, энэ талаархи уг сэтгэгчийн үзэл санааг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Түүний зэрэгцээ тэр үеийн Монголын нийгэм-эдийн засгийн хоцрогдмол харилцаа, мэдлэгийн төвшний хэр хэмжээнээс болж буддын сэтгэгчдийн философи болон нийгмийн үзэл түүхэн хязгаарлагдмал талтай байсныг зохиогч харуулсан байна.

Одоо профессор Ч.Жүгдэр Монголын философи сэтгэлгээний хөгжлийн эхэн үеийн хамарсан судалгаа хийж байгаа бөгөөд үүгээр Монголын философийн түүхийн бүхэл нэгэн тоймыг үндсэнд нь гаргаж дуусгах юм.

Монголын эрдэмтэд буддын философийг судлахдаа Монгол оронд өргөн дэлгэрч, Монголын сэтгэгчдэд илүү ашигтай урсгал чиглэлүүдийг нь голлон анхаарч байдаг. Энэ нь юуны өмнө буддын философийн гол төв урсгал³ гэж зарим эрдэмтэд үздэг мадхьямака (дундад үзэл-хоосон чанарын сургаал), түүнчлэн вайбхашика (өвөрмөц өгүүлэгчийн үзэл), йогачара (сэтгэлийн төдийтний үзэл) болно.

³ T.R: Murti, The central philosophy of Buddhism, L., 1954

Мадьямаха хэмээх дундад үзлийн философийн онолын зарим үндэслэлийг академич Ш.Лувсанвандан⁴ нарийвчлан шинжилсэн юм. Үүнд хоосон чанарын сургаал бол ерөнхий хийгээд тусгай үнэмлэхүй хийгээд янагуухь, хийсвэр хийгээд тодорхой диалектик нэгдлийн үзэл мөн гэж тайлбарлаад, Нагаржунагийн алдарт “найман үгүйсгэл” (түрдэх үгүй төрөх үгүй, тасархай үгүй мөнх үгүй, ирэхүй үгүй олохуй үгүй, ангит утгат бус, нэгэн утгат бус) нь ертөнцийн юмс, үзэгдлийн чанар-тоо, орон цагийн харилцааны тусгал болно гэж үзжээ. Тэгэхэд эдгээр категориуд ертөнцийг хөдлөнгө хийгээд тогтонги байдалд нь түүний эсрэг тэсрэг талуудын бие биеэ харилцан үгүйсгэхийн хамт харилцаа нөхөн нөхцөлдүүлдэг байдалд нь илэрхийлж байгаа юм гэж академич тэмдэглэж байна.

Эртний Энэтхэгийн алдарт сэтгэгч, мадьямака чиглэлийг үндэслэгч Нагаржунагийн философийн үзлийг шинжлэхэд энэ тэмдэглэлийг бичигт судалгаагаа зориулж байна.⁵ Үүнд буддизм, түүний дотор Нагаржунагийн философийг судлах арга зүйн асуудлуудыг боловсруулж, уг сэтгэгчийн нягтад хураасан шасдаруудын утга санааг диалектик материализмын үүднээс тайлан тайлбарлах үндсэн дээр философийн үзлийг нь тодорхойлохыг бид оролдсон юм. Энэхүү судалгааны дүнд: нэгд, Нагаржуна эртний бүхийлэн том философич сэтгэгчдийн нэгэн адил оршин буй бүхний үндсийг эрж, түүнийгээ аливаа тодорхой шинж үгүй хоосон чанар (Шуньята) гэж үзсэн бөгөөд ийнхүү хүртэгдэх юмс, үзэгдэл тэдгээрийн тодорхой шинж, харилцаа бүхнийг орхин гүн гүнзгий хийсвэрлэлд хүрсэн; хоёрт тэрхүү хийсвэрээ (хоосон чанараа) бие даалган орхисонгүй, түүгээр хязгаарласангүй, хоосон чанар дүрс, номын бие хувилгаан бие, нирван сансрыг нягт нэгдэлтэйгээр авч үзэн хийсвэрээс эргэн тодорхойд шилжиж чадсан гуравт, юмсын тогтнон хөгжих аль нэг талыг үнэмлэхүй болгон үзэх өрөөсгөл номлол, сэтгэхүйн метафизик хандлагын эсрэг Нагаржуна тууштай тэмцэж, ертөнцийг эсрэг тэсрэг зөрчилт тал хандлагуудын харилцан үйлчлэл, шүтэлцсэн холбоонд нь, түүнийг жинхэнэ байгаа байдлаар нь хөгжил хувьсал дунд нь авч үзсэн гүнзгий диалектикч сэтгэгч байжээ гэсэн дүгнэлт хийсэн юм.

Монголын нэрд гарсан буддист сэтгэгч Агваандандарын философи-логикийн үзлийг шинжлэн үзэх талаар философийн ухааны дэд эрдэмтэн Т.Содномдаргиа судалгаа хийж бичсэн товхимолдоо уг сэтгэгчийн атомлог сургаалыг авч үзэн, түүний материалист хандлагатайг харуулаад, түүний танин мэдэхүйн болон логикийн үзлийг авч үзэж, агваандандарын силлогизмын дүгнэлтүүдийг ангилан, логикийн түүхийн үүднээс харьцуулан үзжээ.

Эрдэм шинжилгээний залуу ажилтан Г.Лхагвасүрэн йогачара чиглэлийн талаар судалгаа хийж, XIX зууны Монголын сэтгэгч, яруу найрагч Данзанравжаагийн нийгэм-улс төр, философийн үзлийг тусгайлан шинжилж байна.

Түүнчлэн философийн ухааны дэд эрдэмтэн Д.Дагвадорж буддизмын талаар шинжлэх ухааны хялбаршуулсан ном товхимол⁷ нэлээдийг

⁴ Ш.Лувсанвандан, Мадьямака хэмээх дундад үзэл, “философи, эрхийн судлал” 1 боть, 1977; Фонемын онолын тухай асуудал “Хэл зохиол судлал” VI боть, 2 дахь дэвтэр. УБ., 1969

⁵ Г.Лувсанцэрэн. Нагаржунагийн философийн үзэл, УБ. 1981, К изучению философии Нагаржуны “Монголч эрдэмтдийн олон улсын III их хуралботь, УБ., 1979.

⁷ Д.Дагвадорж. Бурхны шашин, УБ., 1971; Шарын шашин. УБ., 1977 зэрэг

бичжээ.Эдгээр номдоо буддын сургаал болон буддын шашны үндсүүдийг авч үзэж, хувьсгалаас өмнөх үеийн Монгол орны нийгэм-улс төрийн амьдралд шарын шашны гүйцэтгэсэн харгис ролийг харуулжээ. Түүнээс гадна Д.Дагвадорж шарын шашны сургаал дахь хүний асуудлыг судалж, шашны номлолын судар ном, тухайлбал Зонхавагийн “Лам рим-ченбо” (Их бодь мөрийн зэрэг) зэрэг зохиолыг задлан шинжлэх үндсэн дээр уг асуудлыг тусгайлан авч үзэж, цогц дүрс, сэтгэл зэрэг хүний тухай шарын шашны ойлголтуудад үнэлэлт дүгнэлт өгч байна.

Буддын философийн зэрэгцээгээр манай эрдэмтэд мөн буддизмын түүх, одон зурхай, анагаах ухаан зэргийн талаар, түүнчлэн Азийн буддистуудын энх тайвны хөдөлгөөн зэрэг орчин үеийн буддизмын асуудлуудаар судалгаа хийж байгаа юм.

Тухайлбал шарын шашин, Монголын шашин сүм хийдийн түүхийн судалгаанд түүхийн ухааны доктор С.Пүрэвжав⁸ ном бүтээлүүдээ зориулжээ. С.Пүрэвжав архивын их хэмжээний материал, ном судруудыг судлан тулгуурлаж Монголд шарын шашин дэлгэрэх түүхэн нөхцөл, дэлгэрсэн явцыг түүхчлэн харуулж Монголын түүхэнд шарын шашны гүйцэтгэсэн үүргийг үзүүлсэн юм.

Одоо БНМАУ-ын ШУА-ийн философи, социологи, эрхийн хүрээлэнгийн буддын судлалтнууд буддын философийн гол урсгалууд болон авхидхарм, мадхьямака, йогачарын сургаалын онолын үндсийг авч үзэж, тэдгээрийн Монголд дэлгэрсэн, уг чиглэлүүдийн төлөөлөгч-Монголын нэрт сэтгэгчдийн философи, логикийн үзлийг цаашид жиллаж байна.

Үүний хамт тус хүрээлэнд хөдөлмөрчдийн шашингүйн хүмүүжлийн талаар социологийн судалгаа явуулж, энэ үндсэн дээр өнөөгийн нөхцөлд сүсэг бишрэл оршин байгаа шалтгаан, түүний илэрч буй хэлбэр, даван туулах арга зам, тус орны үндсэн анги, нийгмийн бүлгүүдэд шинжлэх ухааны шашингүйн үзэл төлөвшсөн төвшинг тодорхойлон харуулсан хамтын бүтээл бичиж, зөвлөмж боловсруулж байна.

БНМАУ дахь буддын философийн судлал төлөвшин хөгжих эхлэлийн шатандаа байгаа бөгөөд буддизмын талаархи судалгааны үндсэн чиглэлийг тогтоон, хэтийн төлөвлөгөө боловсруулж байна. Түүнчлэн нарийн мэргэжлийн боловсон хүчин буддын судлалтнуудыг бэлтгэх ажил хийгдэж байгаа болно.

Тус орны буддын судлалыг хөгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа, юуны өмнө ЗХУ-ын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтран ажиллаж, тэдний судалгааны ажлын баялаг туршлагаас сурч эзэмших явдал онцгой чухал ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд Зөвлөлтийн эрдэмтэдтэй хамтран Монголын философийн түүх судлалын онол-арга зүйн болон буддын судлаачдын зарим асуудлаар хамтын судалгаа хийж эхэллээ. Мөн Зөвлөлт, Монголын буддын судалтнуудын уулзалт симпозиум хийж эхэлж байна. Энэ бүхэн нь манай орны судалгааны онол-шинжилгээний төвшинг өндөржүүлж, чанарыг сайжруулах, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болж байгаа юм.

⁸ С.Пүрэвжав. Хувьсгалын өмнөх Их хүрээ. УБ., 1961; Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978

Төгсгөлд нь хэлэхэд, Монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүх түүний дотор буддын философи Монголд дэлгэрэн хөгжсөн түүхийн судалгаа нь Монголын философи сэтгэлгээ өөрийн өвөрмөц онцлогтой болохыг гэрчлэхийн хамт Монголын сэтгэгчид мөн л философийн нийтлэг асуудлууд, тухайлбал онтологи, танин мэдэхүй, арга зүй, логик социологийн асуудлуудыг олон зуун жилийн турш эрхлэн судалж, философи сэтгэхүйг хөгжүүлж ирснийг нотлон харуулж байна.

Г.Лувсанцэрэн